

БӨӨНИЙ ХУДАЛДАА ХК

2016.04.30

ХУВЬЦАА
ЭЗЭМШИГЧДИЙН
ЭЭЛЖИТ ХУРАЛД
ЗОРИУЛАВ

Лавлах утас 976-99111286



БӨӨНИЙ ХУДАЛДАА ХУВЬЦААТ КОМПАНИ
ХУВЬЦАА ЭЗЭМШИГЧДИЙН ЭЭЛЖИТ ХУРЛЫН ТЭМДЭГЛЭЛ

2016 оны 4сарын 30 өдөр

Улаанбаатар хот

Бөөний худалдаа хувьцаа эзэмшигчдийн хуралдаан 2016 оны 04 сарын 30-ны өдрийн 13:00 цагт Улаанбаатар хотын Баянгол дүүрэг 20-р хороо, Бөөний худалдаа ХК-ийн 101 тоотод эхлэв.

ТУЗНБД С.Оюунгэрэл хурлын ирцийг танилцуулав.

	Хувьцаа эзэмшигч	Хувьцааны тоо	Нийт хувьцаанд эзлэх хувь
1	Б.Очбадрах	727441 ширхэг	57.16%
2	Б.Илчбадрах	270806 ширхэг	21.28%
3	Б.Дөлбадрах	5945 ширхэг	0.74%
	Нийт	1004192 ширхэг	79.18%

Хувьцаа эзэмшигчдийн хуралдааны ирц нь Компанийн тухай хуулийн 69 дүгээр зүйл 69.1-д заасан нөхцлийг хангасан байна.

Хурлын дарга Б.Дөлбадрах

Хуралд хүрэлцэн ирсэн эрхэм хувьцаа эзэмшигчиддээ баярлалаа. Энэ удаагийн ээлжит хуралд ТУЗ-ийн бүх гишүүд оролцож байгаад таатай байна.

Ингээд хэлэлцэх асуудалдаа шууд орё.

Хурлын дарга Б.Дөлбадрах ТУЗ-ийн 006 тоот тогтоол болон 003, 004 тоот тогтоолуудыг уншин танилцуулав.

.... Та бүхэн нэгэнт хэлэлцэх асуудалтайгаа танилцсан байгаа тул асууж тодруулах зүйлээ асуугаад саналаа хураагаад явах саналтай байна.

Б.Илчбадрах: Надад нэг тодруулах зүйл байна. Компанийн хэлбэрийг өөрчлөх төсөл бэлтгэхийг 2 жил дараалан даалгасан тогтоол гарсан боловч одоо болтол хэрэгжээгүй байна. Энэ дээр тийм их судалгаа, зардал шаардлагтай байгаа юм бол мэргэжлийн хүмүүсийн хөлслөөд ажиллуулмаар байна. Энэ жилтэй нийлээд 3 дахь жилдээ энэ асуудлыг хөндөн ярьж байна. Одоо бас ахин зөвшөөрөл хүсэхээр тогтоолын төсөл бэлтгээд ирсэн. Үүнийг хэрхэн шийдэх вэ. Нэг бол ХК чигээрээ ингээд яваад байх юмуу,

Б.Дөлбадрах: Одоо хувьцаа эзэмшигчид байгаа дээрээ энэ асуудалд нь ач холбогдол өгөөд, гаднаас мэргэжлийн баг ажиллуулах зөвшөөрлийг нь өгөө. Харин 2 жил дараалан энэ асуудлыг ярьж байгаагийн шалтгаан нь ганцхан санхүүгийн асуудал уу үгүй юу гэдгийг Компанийн удирдлагууд судлан тогтоогоод ТУЗ-өөр дамжуулан мэдэгдмээр байна.

Б.Очбадрах: Хувьцаа эзэмшигчид өөрсдөө ТУЗ-д ажилласан болохоор нэмж өөрсөддөө дахин тайлбарлах хэрэг алгаа тэгэхээр саналаа хураая.

Хурал зохион байгуулах болон тооллогын комиссын дарга санал хураалтыг эхлүүлж, 13:45 цагт тооллын комиссын дүнг танилцуулав.

С.Оюунгэрэл өнөөдрийн хуладаанд эчнээ байдлаар санал өгсөн хувьцаа эзэмшигч байхгүй нийт 1004192 ширхэг саналын эрхтэй хувьцаа эзэмшигч оролцлоо. Тооллогын комиссоос дараахи тогтоолыг гаргаж байгаа бөгөөд тогтоолд саналын хуудсыг хавсаргасан болно.

Дараахи тогтоолын төсөлд санал хураалт явууллаа.

Нийт 1004192 ширхэг саналын эрхтэй хувьцаа эзэмшигчид оролцон 3 хүчинтэй саналын хуудас тоолоо. Хүчингүй болсон саналын хуудас байхгүй

	Хэлэлцсэн асуудал	Тогтоолын төслийн дугаар	Зөвшөөрсөн	Татгалзсан	Түдгэлзсэн
1	Компанийн 2015 оны үйл ажиллагааны болон санхүүгийн тайлангийн дүгнэлт	001	1004192		0
5	ТУЗ-ийн 2015 оны үйл ажиллагааны тайланг дүгнэх тухай	002	1004192		0
6	ТУЗ-ийн гишүүдийн бүрэн эрхийг сунгах тухай	003	1004192		0
7	Компанийн хэлбэрийг өөрчлөх төсөл эхлүүлэх зөвшөөрөл олгох тухай	004	1004192		0

Шийдвэрлсэн нь .

Хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурлаар

001,002,003,004, тоот тогтоолын төслийг 100 хувь дэмжин тогтоол гаргаж, энэ тухай холбогдох байгууллагуудад хүргүүлэхийг ТУЗНБД-д үүрэг болгов.

Хуралдаан 2015 оны 04 сарын 30-ны 14:56 цагт өндөрлөв.

ТЭМДЭГЛЭЛ ХӨТӨЛСӨН

ТУЗНБД

ХЯНАСАН

ХУРЛЫН ДАРГА

С.ОЮУНГЭРЭЛ
Б.ДӨЛБАДРАХ
ТТА4



БӨӨНИЙ ХУДАЛДАА ХУВЬЦААТ КОМПАНИ
ТООЛЛОГЫН КОМИССЫН ТОГТООЛ

2016 оны 4 сарын 30 өдөр

Дугаар №1/1

Улаанбаатар хот

ХУРАЛ ХҮЧИН ТӨГӨЛДӨРТ ТООЦОХ,
САНАЛ ХУРААХ ХУУДАС ТООЛСОН ТУХАЙ

Бөөний худалдаа ХК-ийн 2016 оны 4 сарын 30-ны өдрийн хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурлын ирц, тооллогын комиссын дүнг үндэслэн, Компанийн тухай хуулийн 63 дугаар зүйл, 63.4 дэх заалт, 67 дугаар зүйлийг тус тус удирдлага болгон ТОГТООХ нь:

НЭГ. Компанийн 2015 оны Хувьцаа эзэмшигчдийн ээлжид хуралдаанд 1004192 ширхэг саналын эрхтэй 79.18 хувийн 3 хувьцаа эзэмшигч хуралд оролцож санал өгсөн байх тул хувьцаа эзэмшигчдийн хурлыг хүчин төгөлдөрт тооцсугай.


ХОЁР. Хувьцаа эзэмшигчдийн ээлжит хуралд эчнээ байдлаар урьдчилан өгсөн саналын хуудас байхгүй болохыг дурьдсугай.

ГУРАВ. Хувьцаа эзэмшигчдийн хурлын саналын хуудасны тооллогоор 1004192 ширхэг саналын эрхтэй 3 ширхэг хүчинтэй саналын хуудас тоолсон бөгөөд хүчингүй саналын хуудас тоологдоогүй болохыг мэдэгдсүгэй.

ДӨРӨВ. Хувьцаа эзэмшигчдийн ээлжит хуралдаанаар хэлэлцсэн асуудал, хуралдаан болон санал хураалтын ирц, саналын хуудасыг үндэслэн хэлэлцсэн асуудалд өгсөн санал нь дараахи дүнд хүрсэн болохыг батласугай.

№	Хэлэлцэх асуудал	Зөвшөөрсөн	Татгалзсан	Түдгэлзсэн
1	Компанийн 2014 оны үйл ажиллагааны болон санхүүгийн тайлангийн дүгнэлт/ 001 тоот тогтоолын төсөл/	1004192	0	0
2	Ногдол ашгийн тухай тогтоолыг танилцуулах тайлбар хийх		-	0
3	ТУЗ-ийн 2014 оны үйл ажиллагааны тайланг дүгнэх тухай / 002 тоот тогтоолын төсөл/	1004192	0	0
4	ТУЗ-ийн гишүүдийн бүрэн эрхийг сунгах тухай /003 тоот тогтоолын төсөл/	1004192	0	0
5	Компанийн хэлбэрийг өөрчлөх төсөл эхлүүлэх зөвшөөрөл олгох тухай 004 тоот тогтоолын төсөл	1004192	0	0

ХУРЛЫН ДАРГА  Б.ДӨЛБАДРАХ





БӨӨНИЙ ХУДАЛДАА ХУВЬЦААТ КОМПАНИ
ХУВЬЦАА ЭЗЭМШИГЧДИЙН ЭЭЛЖИТ ХУРЛЫН ТОГТООЛ

2016 оны 4 сарын 30 өдөр

Дугаар №001

Улаанбаатар хот

2015 ОНЫ САНХҮҮГИЙН ҮЙЛ АЖИЛЛАГААГ ДҮГНЭХ ТУХАЙ

Бөөний худалдаа ХК-ийн 2016 оны 4 сарын 30-ны өдрийн хувьцаа эзэмшигчдийн хурлын тэмдэглэл, тооллогын комиссын дүнг үндэслэн, Компанийн тухай хуулийн 62 дугаар зүйл, 62.1.9 дэх заалтыг удирдлага болгон ТОГТООХ нь

НЭГ: Компанийн 2015 оны санхүүгийн үйл ажиллагааны тайлангийн дүгнэлттэй танилцан Би Энд Си Аудит ХХК-ийн гаргасан дүгнэлтийг хүлээн зөвшөөрсүгэй.

ХОЁР: 2015 оны үйл ажиллагааг хэвийн тасралтгүй явуулахыг ТУЗ-д даалгасугай

ХУРЛЫН ДАРГА  Б.ДӨЛБАДРАХ





БӨӨНИЙ ХУДАЛДАА ХУВЬЦААТ КОМПАНИ
ХУВЬЦАА ЭЗЭМШИГЧДИЙН ЭЭЛЖИТ ХУРЛЫН ТОГТООЛ

2016 оны 4сарын 30 өдөр

Дугаар №003

Улаанбаатар хот

ТУЗ-ИЙН ГИШҮҮДИЙН БҮРЭН ЭРХИЙГ СУНГАХ ТУХАЙ

Бөөний худалдаа ХК-ийн 2016 оны 4 сарын 30-ны өдрийн хувьцаа эзэмшигчдийн хурлын тэмдэглэл, тооллогын комиссын дүнг үндэслэн Компанийн тухай хуулийн 62.1.9 дэх заалтыг удирдлага болгон ТОГТООХ нь:

НЭГ. Нэр дэвшүүлэх хорооноос санал болгосны дагуу ТУЗ-ийн дараахи гишүүдийн эрхийг 2017 оны хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурал хүртлэх хугацаагаар сунгасугай.

1. Б.Дөлбадрах
2. Б.Илчбадрах
3. Б.Очбадрах
4. Ж.Бадарч
5. Д.Мөнгөнцэцэг
6. Б.Болд

ХОЁР. Нэр дэвшүүлэх хорооноос санал болгосны дагуу ТУЗ-ийн дараахи хараат бус гишүүдийн эрхийг 2017 оны хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурал хүртлэх хугацаагаар сунгасугай.

1. А.Болоржаргал
2. Б.Батцэцэг
3. Ү.Нармандах

ГУРАВ. ТУЗ-ийн гишүүнээр улиран сонгогдсон нийт гишүүдэд баяр хүргэж, Компанийн засаглалын Кодексыг хэрэгжүүлэхийг даалгасугай.

ХУРЛЫН ДАРГА

Б.ДӨЛБАДРАХ



БӨӨНИЙ ХУДАЛДАА ХУВЬЦААТ КОМПАНИ
ХУВЬЦАА ЭЗЭМШИГЧДИЙН ЭЭЛЖИТ ХУРЛЫН ТОГТООЛ

2016 оны 4сарын 30 өдөр

Дугаар №004

Улаанбаатар хот

КОМПАНИЙН ХЭЛБЭРИЙГ ӨӨРЧЛӨХ ТӨСӨЛ ЭХЛҮҮЛЭХ ТУХАЙ

Бөөний худалдаа ХК-ийн 2016 оны 4 сарын 30-ны өдрийн хувьцаа эзэмшигчдийн хурлын тэмдэглэл, тооллогын комиссын дүнг үндэслэн, Компанийн тухай хуулийн 62.1.4 дэх заалтыг удирдлага болгон **ТОГТООХ** нь:

НЭГ. Компанийн хэлбэрийг өөрчлөхөөр ТУЗ-өөс гаргасан саналыг үндэслэлтэй гэж үзэн дэмжсүгэй.

ХОЁР. Компанийн хэлбэрийг өөрчлөх болсонтой холбогдуулан Компанийн хэлбэрийг өөрчлөх тухай төсөл боловсруулахыг ТУЗ-ийн нийт гишүүдэд даалгасугай.

ГУРАВ. Компанийн хэлбэрийг өөрчлөх тухай төслийг боловсруулахдаа мэргэжлийн экспертийн баг ажиллуулахыг ТУЗ-д зөвшөөрсүгэй.

ДӨРӨВ. Төслийн судалгааг үндэслэлтэй хийж, дараахи мэдээллүүдийн цогц шинжилгээг гаргасугай.

- Хэлбэрийг өөрчлөх зорилго
- Нөхцөл
- Журам
- Хувьцааг харилцан хөрвүүлэх арга
- Тооцоо
- Өөрчлөлт оруулах хугацаа
- Хувьцаа эзэмшигчдийн хуралд танилцуулах хугацаа

ТАВ. Компанийн хэлбэрийг өөрчлөх тухай асуудлыг зарчмын хувьд дэмжин, төсөл боловсруулж танилцуулсаны дараа ахин хэлэлцэхээр тогтсугай.

ХУРЛЫН ДАРГА  Б.ДӨЛБАДРАХ

